

Зарим тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг түр
хүлээн авахгүй байх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1, 34.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр авахаар ирүүлж буй хүсэлтийг “Монголын хөрөнгийн бирж” ХК дахь суудлын хүртгэмжийг нэмэх, татан буугдсан болон тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон компаниудын харилцагчдыг тусгай зөвшөөрөл бүхий бусад компаниудад шилжүүлэх, дээрх мэргэжлийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журам, үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүртэл түр хүлээн авахгүй байхаар тогтсугай.

2.Энэхүү тогтоол батлагдахаас өмнө ирүүлсэн хүсэлтийг зохих журмын дагуу шийдвэрлүүлэхийг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ